

УЛААНБААТАР ХОТ  
БАТЛАВ  
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.МӨНХӨӨ

БАТЛАВ  
ӨЛЗИЙГ ТӨМӨРТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Ж.БАДАМХОРОЛ

**ТҮЛШ ДАМЖУУЛАХЫН СЭЛБЭГ, ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАХ,  
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

2023 оны 08-р сарын 17 өдөр

Дугаар.. 2023/68

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө, нөгөө талаас Өлзийт төмөрт ХХК-ийг төлөөлж захирал Ж.Бадамхорол /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29-р зүйлийн 29.2 дахь заалт, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

**Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл**

- 1.1 Нийлүүлэгч нь “Түлш дамжуулахын сэлбэг, хэрэгсэл” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан нэр төрөл, тоо хэмжээ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу захиалагчийн агуулахад нийлүүлнэ.

**Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа**

- 2.1 Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 30 хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

**Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл**

- 3.1 Энэ гэрээний нийт үнэ 34,600,000 /гучин дөрвөн сая зургаан зуун мянга/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль онцгой албан татвар, захиалагчийн агуулахад хүргэх, тээврийн зардал, НӨАТ бүгд орсон байна.
- 3.2 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.3 Барааг хүлээлгэн өгсөний дараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 90 хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Голомт банк 1415138668 тоот дансанд шилжүүлнэ.

**Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага**

- 4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 4.2 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.

Захиалагч:

1/4

Нийлүүлэгч:

- 4.3 Нийлүүлэх барааг захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолтод нийцэж буй эсэхийг хянах зорилгоор баталгаат итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ хийнэ.
- 4.4 Баталгаат шинжилгээтэй холбоотой аливаа зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 4.5 Барааг захиалагчийн агуулахад ирсний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана. Буцаах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.
- 4.6 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Хангамжийн мэргэжилтэн М.Моломжав. Утас-99122684
- 4.7 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээний холбоотой асуудлыг Өлзийт төмөрт ХХК-ийн захирал Ж.Бадамхорол хариуцан ажиллана. Утас-99037645.

#### **Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол**

- 5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2 Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед гэмтэж цоорохоос хамгаалсан сав, баглаа, боодолтой байна.
- 5.3 Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4 Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5 Нийлүүлэгч нь нийлүүлсэн бараанд 1 жилийн баталгаа гаргана. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл согог, дутагдлыг өөрийн зардлаар засаж залруулах, сольж өгөх үүрэгтэй.

#### **Зургаа. Бараа хүлээн авах**

- 6.1 Нийлүүлэгч нь ачигдсан барааг захиалагчийн агуулахад хүргэх ба захиалагч талаас бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2 Нийлүүлэгч нь барааг захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

#### **Долоо. Давагдашгүй хүчин зүйл**

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд гэрээний хугацаа дуусахаас өмнө талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

#### **Найм. Гэрээг цуцлах үндэслэл**

- 8.1 Нийлүүлэгч нь барааг энэхүү гэрээний 2.1-т заасан материал нийлүүлэх хугацаанаас хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцална.

Захиалагч:



2/4

Нийлүүлэгч: *Ч. Бадамхорол*

8.2 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

### Ес. Бусад нөхцөл

- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд 1 удаа сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


АХЛАХ ИНЖЕНЕР

 Т.АНГАРАГ

СЭЭХ-ИЙН ДАРГА  
БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ

 Ө.УДВАЛ


АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

 Г.БАТТУЛГА

ТҮЛШ ДАМЖУУЛАХ ЦЕХИЙН  
ДАРГА

 Б.ТҮВШИНЗАЯА

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :3  
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН

 М.МОЛОМЖАВ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1  
Утасны дугаар: 77111251  
РД: 6021646

#### НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ӨЛЗИЙГ ТӨМӨРТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ Ж.БАДАМХОРОЛ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, эрдэнэ толгой 51 гудамж, 314 тоот  
Утасны дугаар: 99037645  
РД: 6570747

Захиалагч:



3/4

Нийлүүлэгч: